

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2022/186/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: У.Ербол Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Залруулсан алдаа .....	14
4.2 Төлбөрийн акт .....	14
4.3 Албан шаардлага .....	14
4.4 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХҮЕГ	Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний Ерөнхий газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
А.ГАЛИЯ ТАНАА**

᠒᠐᠒᠒.᠐᠗.᠒᠑ № ᠘᠑7  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн одог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,559,965,141.25</u></b>	<b><u>1,477,860,356.00</u></b>
33	<b>АВЛАГА</b>	1,559,965,141.25	1,477,860,356.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,154,585.25	3,822,000.00
335	<b>Бусад авлага</b>	1,557,810,556.00	1,474,038,356.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,557,810,556.00	1,474,038,356.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,559,965,141.25</u></b>	<b><u>1,477,860,356.00</u></b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>84,829,100.00</u></b>	<b><u>-</u></b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	84,829,100.00	-
413	Өглөг	84,829,100.00	-
4136	<b>Бусад өглөг</b>	84,829,100.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	56,478,800.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	28,350,300.00	-
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,475,136,041.25</u></b>	<b><u>1,477,860,356.00</u></b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,475,136,041.25	1,477,860,356.00
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,475,136,041.25	1,477,860,356.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,475,136,041.25	1,483,981,456.00
51220	Тайлант үеийн үр дүн		(6,121,100.00)
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,559,965,141.25</u></b>	<b><u>1,477,860,356.00</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>614,739,041.00</b>	<b>745,775,210.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,646,941.00</b>	<b>4,088,460.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,646,941.00	4,088,460.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	7,646,941.00	4,088,460.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,646,941.00	4,088,460.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>607,092,100.00</b>	<b>741,686,750.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	351,000,000.00	726,371,750.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	351,000,000.00	726,371,750.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	256,092,100.00	15,315,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	24,060,000.00	15,315,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	232,032,100.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>654,926,855.75</b>	<b>751,896,310.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>654,926,855.75</b>	<b>751,896,310.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	8,766,500.00	7,782,550.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,366,500.00	7,048,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,900,000.00	5,548,150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,466,500.00	1,500,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,400,000.00	734,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,400,000.00	734,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	646,160,355.75	744,113,760.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	356,155,000.00	311,313,250.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	356,155,000.00	311,313,250.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	8,953,141.00	4,088,460.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,953,141.00	4,088,460.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	22,818,900.00	42,681,850.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,818,900.00	42,681,850.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	258,233,314.75	386,030,200.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	258,233,314.75	386,030,200.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(40,187,814.75)</b>	<b>(6,121,100.00)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(40,187,814.75)</b>	<b>(6,121,100.00)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрс үлдэгдэл			1,475,136,041.25		1,475,136,041.25
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өсөлт, бууралт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,475,136,041.25	0.00	1,475,136,041.25
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй өсөлт, бууралт					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	0.00	0.00	1,475,136,041.25	0.00	1,475,136,041.25
D01	2020 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	0.00	0.00	1,475,136,041.25	0.00	1,475,136,041.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өсөлт, бууралт			8,845,414.75		8,845,414.75
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,483,981,456.00	0.00	1,483,981,456.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй өсөлт, бууралт					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-6,121,100.00		-6,121,100.00
D09	2021 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	0.00	0.00	1,477,860,356.00	0.00	1,477,860,356.00

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>875,094,841.00</b>	<b>745,775,210.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>268,002,741.00</b>	<b>4,088,460.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	268,002,741.00	4,088,460.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	268,002,741.00	4,088,460.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	260,355,800.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,646,941.00	4,088,460.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>607,092,100.00</b>	<b>741,686,750.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	351,000,000.00	726,371,750.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	351,000,000.00	726,371,750.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	256,092,100.00	15,315,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	24,060,000.00	15,315,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	232,032,100.00	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>875,094,841.00</b>	<b>1,134,547,410.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>875,094,841.00</b>	<b>1,134,547,410.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>7,766,500.00</b>	<b>8,782,550.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,366,500.00	8,048,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,900,000.00	6,548,150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,466,500.00	1,500,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,400,000.00	734,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,400,000.00	734,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>867,328,341.00</b>	<b>1,125,764,860.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	579,825,900.00	689,142,350.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	579,825,900.00	689,142,350.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	8,953,141.00	5,168,460.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,953,141.00	5,168,460.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	20,315,985.25	42,681,850.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,315,985.25	42,681,850.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	258,233,314.75	388,772,200.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	258,233,314.75	388,772,200.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-</b>	<b>(388,772,200.00)</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
14	Бусад эх үүсвэр	-	388,772,200.00
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>388,772,200.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	764,186,750.00	697,924,900.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	764,186,750.00	697,924,900.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	19,863,200.00	8,782,550.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,048,200.00	8,048,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	5,548,200.00	6,548,150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	12,815,000.00	734,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,815,000.00	734,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	744,323,550.00	689,142,350.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	744,323,550.00	689,142,350.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	744,323,550.00	689,142,350.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	764,186,750.00	697,924,900.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	748,871,750.00	694,690,500.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	748,871,750.00	694,690,500.00
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	15,315,000.00	3,234,400.00
122001	Хандив тусламж /дотоод/	15,315,000.00	3,234,400.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1/31 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох, ядуурлыг бууруулах, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг чанаржуулах, монгол хүний амьдралын чанарыг сайжруулахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Захиргаа, хяналтын хэлтсээс төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх бүрд хяналт тавьж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 654.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 6.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 82.1 сая төгрөгөөр буюу 5.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	1559965.1	1477860.4	-82104.7
Урьдчилгаа	0.00	0.00	0.0
Бараа материал	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгө	0.00	0.00	0.00
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1559965.1</b>	<b>1477860.4</b>	<b>-82104.7</b>
Өр төлбөр	84829.1	0	-84829.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1475136.0	1477860.4	2724.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1559965.1</b>	<b>1477860.4</b>	<b>82104.7</b>

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл 1477.8 сая төгрөг болж 82.1 сая төгрөгөөр буурсан нь татаас, санхүүжилтийн авлага 1.6 сая төгрөгөөр нэмэгдэж, хувь хүмүүсээс авах авлага 83.7 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Авлагын данс оны эхэнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгийн 1557.8 сая төгрөгийн авлагатайгаас тайлант онд 388.7 сая төгрөгийн авлагыг барагдуулж, 100 иргэнд 305.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, нийт дүнгээр 83.7 сая төгрөгөөр буурсан байна.

Татаас, санхүүжилтийн авлага нь 3.8 сая төгрөг болж өмнөх оноос 1.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 84.8 сая төгрөгийг барагдуулсан байна.

Энэ нь Ковид-19 цар тахал өвчин гарсантай холбогдуулан 2020 оны батлагдсан төсвөөс 84.8 сая төгрөгийг дутуу олгосныг тайлант онд нөхөн олгож, өр төлбөрийг бүрэн барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1477.8 сая төгрөг болж 2.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 745.7 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 131.0 сая төгрөгөөр буюу 21.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн санхүүжилт, хандив тусламжийн данс байна.

Нийт зардал өмнөх оноос 96.9 сая төгрөгөөр буюу 14.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлууд байна. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, урсгал шилжүүлгийн зардал өмнөх оноос нэмэгдэж, бараа үйлчилгээний бусад зардал буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар 8.8 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдсэн нь 2.2 сая төгрөгийн татаас, санхүүжилтийн авлагыг Сангийн яамнаас ХХҮЕГ-т шууд барагдуулснаар өмнөх үеийн үр дүнд нөлөөлсөн, урьд оны 84.8 сая төгрөгийн өглөгөөс санхүүгийн дэмжлэгт олгосон 11.0 сая төгрөгийг хувь хүнээс авах авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны анх батлагдсан төсөв 729.8 сая төгрөг, тодотгосон төсөв 748.9 сая төгрөг байна. Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 19.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлөөс хөдөлмөрийн зах зээлийн туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь тайлант онд үндсэн үйл ажиллагааны төсөв нь 748.8 сая, хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн хүрээнд 15.3 сая төгрөг нийт 764.2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулжээ.

Гүйцэтгэлээр үйл ажиллагааны санхүүжилтээр 694.7 сая, хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн хүрээнд 3.2 сая, нийт 697.9 сая төгрөгийн санхүүжилт авсан ба үйл ажиллагааны санхүүжилтээс 22.5 сая төгрөг дутуу авсан, жилийн эцэст хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрөөс 12.1 сая, төсвийн санхүүжилтээс 30.6 сая төгрөгийг ХХҮЕГ-т, 1.1 сая төгрөгийг Сангийн яамд татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Нэмэлт төсвөөр орлого зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 онд нийт 1134.5 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1134.5 сая төгрөгийн 100 мэдээллийг хугацаандаа бүрэн байршуулж, 396.2 сая төгрөгийн 49 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны хугацаа хоцроосон 35 мэдээллийг цаг тухайд нь оруулж ажиллах талаар зөвлөмж өгөгдсөнийг давтан шалгаж үзэхэд зөрчлийг давтан гаргасан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалтыг цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан түүвэрлэн шалгасан тул нэгдсэн удирдамжаар хийх гүйцэтгэлийн аудитаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар шилэн дансны 396.2 сая төгрөгийн 49 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд мэдээллийг хуулийн бүрэн хугацаанд оруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлээ.

### **4.1 Залруулсан алдаа**

Байхгүй

### **4.2 Төлбөрийн акт**

Байхгүй.

### **4.3 Албан шаардлага**

Аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 396.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2021 онд нийт 1134.5 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдэн цахим хуудаст ил тод байршуулахаас 396.2 сая төгрөгийн 3, бусад мэдээллээс 46 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

#### 4.4 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	396.2					1	396.2		